



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, ШУА-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн "в" дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоол, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн үлгэрчилсэн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. ШУА-ийн харьяа Тархи, сэтгэл судлалын хүрээлэнгийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.РЭГДЭЛ

Шинжлэх ухааны Академийн
Ерөнхийлөгчийн 2022 оны 2-р
дугаар сарын 18-н өдрийн А
дугаар тушаалын хавсралт



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТАРХИ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шинжлэх ухааны академийн харьяа Тархи, сэтгэл судлалын хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэнэ/ нь Монгол Улсад тархи, сэтгэл судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, салбар хоорондын судалгааны платформ бий болгох, нийгмийн сэтгэлзүйн өөрчлөлт, хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийн оношилгоо, эмчилгээг нотолгоонд суурилсан шинжлэх ухааны техник аргачлалаар судлах үндсэн чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний мэргэжлийн төрөлжсөн байгууллага мөн.

1.2. Хүрээлэн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын бусад хууль тогтоомж болон ШУА-ийн дүрмийг мөрдлөг болгоно.

1.3. Хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагааг энэхүү дүрэмтэй нийцүүлэн гаргасан хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна. Хүрээлэнгийн дүрэм, дотоод журмыг хүрээлэнгийн бүх ажилтнуудын хурлаар хэлэлцэж, дүрмийг ШУА-ийн Ерөнхийлөгч, дотоод журмыг Захирал батална.

1.4. Хүрээлэн нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкны харилцах данс бүхий хуулийн этгээд мөн. Хүрээлэн нь цахим хуудас, билэг тэмдэг, туг, онцлогоо тусгасан брэнд бүүк болон бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг

2.1. Хүрээлэнгийн үндсэн зорилт нь тархи судлал, сэтгэл судлалын болон салбар дундын шинжлэх ухааныг хөгжүүлэх, судалгаа-боловсруулалтын ажил эрхлэх, төсөл хэрэгжүүлэх, үндэсний мэргэжилтэн бэлтгэх, ажлын байр бүрдүүлж эрхзүйн орчноор хангах, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, инновацийг бий болгож үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд оршино.

2.2. Хүрээлэн үйл ажиллагаандаа ардчилсан зарчим, хууль дээдлэх ёс, шинжлэх ухааны ёс зүй, бүтээлч хандлага, академик эрх чөлөө, тэгш байдал, ил тод, хариуцлагатай, шуурхай байдлыг удирдлага болгож захиргааны болон хамтын удирдлагын зарчмыг зохистой хослуулан хэрэгжүүлнэ.

2.3. Хүрээлэн нь дор дурьдсан үндсэн чиг үүрэг хэрэгжүүлнэ.

а/ хүн амын дундах тархи, мэдрэлийн эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны хөгжил, хэвийн үзүүлэлт, төвшинг тогтоох; мэдрэл, сэтгэцийн эмгэгийн шалтгаан, механизм, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, нөлөөлөх хүчин зүйлсийг судлахын тулд тархи судлал, сэтгэл судлалын салбарын суурь судалгаа, эмнэлзүйн судалгаа, хүн амзүйн судалгаа, хэрэглээний шинжлэх ухааны судалгаа хийж гүйцэтгэх;

б/ олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, захиалгат болон судалгааны бусад төслүүдийг гүйцэтгэх. судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг амьдрал практикт нэвтрүүлэх;

в/ эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл хэвлүүлэх; бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох;

г/ тархи судлалын шинжлэх ухааны үндэсний мэргэжилтэн, эрдэмтдийн залуу халааг бэлтгэхийн тулд төгсөлтийн /ахисан төвшний/ сургууль байгуулах; тархи судлалын чиглэлээр тэргүүлэх судлаачдын Пи-Ай тогтолцоог нэвтрүүлэх; тархи судлал, сэтгэл судлалын салбарын мэргэжилтэнд зориулсан мэргэшлийн сургалт зохион байгуулах; эрдэм шинжилгээний ажилтнуудыг гадаадад сургах; гадаад, дотоодын судлаачдыг урьж хамтран ажиллах боломжоор хангах;

д/ зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран судалгааны лаборатори, төв, платформ, туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, гарааны компани, инновацийн зөвлөх компани, эмийн үйлдвэр, эмийн сан, эмнэлэг, сувилал, бусад нэгж үүсгэн байгуулах; судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах, оюуны өмчийг бүртгүүлэх, эрхийн хамгаалалт хийх;

е/ төр-хувийн хэвшил-шинжлэх ухааны байгууллагуудын түншлэл, энтрепренершип хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд менежментийн гэрээгээр хамтран ажиллаж зохих зөвшөөрлийн дагуу тархи, сэтгэл судлал, мэдрэл, сэтгэцийн лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцэд нөлөөт эм, эмийн бэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, борлуулах;

ё/ эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааныхаа үр дүнг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах.

Гурав. Хүрээлэнгийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Хүрээлэнгийн хамтын удирдлагын хэлбэр нь эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл байна. Захиргааны удирдлагыг захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбарын эрхлэгч, төвийн дарга нар, мэргэжил, арга зүйн удирдлагыг төслийн удирдагчид хэрэгжүүлнэ.

3.2. Хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтын үндсэн нэгж нь салбар, төв байна. Хүрээлэнгийн бүтцийг ШУА-ийн Тэргүүлэгчид батална.

3.3. Судалгааны ажлын онцлогоосоо хамааран үндсэн салбар нь дотроо судалгааны лаборатори, судалгаа туршилт үйлдвэрлэлийн цех зэрэг бусад нэгж байгуулж болно. Судалгаа туршилтын түшиц бааз нь эмнэлэг, сувилал, сургууль, зөвлөх үйлчилгээний төв байж болно.

3.4. Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор салбар дундын трансляц, инновацийн төв нь инновацийн зөвлөх компани, гарааны компани, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан, эмийн үйлдвэр, ахисан төвшний сургууль, залуу судлаачдын клуб зэрэг бусад нэгж байгуулж болно. Гарааны компани нь эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, лабораторийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, дээд боловсролын сургалт эрхлэх зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшиж болно. Үүнтэй холбоотой магадлан итгэмжлэл, тусламж үйлчилгээний хүрээ, дагаж мөрдөх дүрэм, журмыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж мөрдөнө.

Дөрөв. Эрдмийн зөвлөл

4.1. Эрдмийн зөвлөл нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлох, түүний явц, үр дүн, эрдмийн бүтээлийн талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, хүрээлэнгийн захиралд зөвлөх чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний –ажлын хамтын удирдлагын хэлбэр болно.

4.2. Эрдмийн зөвлөлийг хүрээлэнгийн захирал даргалах ба бүрэлдэхүүний тухай хүрээлэнгийн саналыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батална.

4.3. Хүрээлэнгийн эрдмийн зөвлөл нь тухайн хүрээлэнгийн тэргүүлэх эрдэмтдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүний 25 хүртэл хувийг тухайн салбарын бусад эрдэмтэн судлаачид, холбогдох төр, орон нутгийн болон бизнесийн байгууллагын төлөөлөлөөс бүрдүүлж болно.

4.4. Эрдмийн зөвлөл дараах үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

а/ Хүрээлэнгийн судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, эрдэм шинжилгээний ажлын онол арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал дүгнэлт гаргах;

б/ Хүрээлэнгийн эрхэм зорилгыг тодорхойлж үйл ажиллагааны дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

- в/ Хэрэгжүүлэх судалгааны төслүүдийн саналыг хэлэлцэн дэвшүүлэх;
- г/ эрдэм шинжилгээний ажлын хөтөлбөр, төслийн явц, үр дүнгийн байдлыг хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгөх, тэдгээрийн явц, гүйцэтгэлийн эцсийн үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;
- д/ эрдэм шинжилгээний ажлын тайланг хэлэлцэх;
- е/ хүрээлэнгийн дүрэм, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн саналаа академийн тэргүүлэгчдэд хүргүүлэх;
- ё/ хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын ажлын явц, үр дүн, туурвисан судалгааны бүтээлийг хэлэлцэж, хэвлэн нийтлэх талаар санал дүгнэлт гаргах;
- ж/ эрдэм шинжилгээний ажилтанд бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах;
- з/ эрдэм шинжилгээний ажилтнуудыг шагнаж урамшуулах, мэргэжил дээшлүүлэх асуудлыг хэлэлцэж зохих шийдвэр гаргах;
- и/ хүрээлэнгийн хүндэт профессор, зочин профессор цол олгох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

4.5. Эрдмийн зөвлөлийн ажиллах хэлбэр нь хуралдаан байна. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба хурлаас тогтоол, тэмдэглэл гаргана. Тогтоолд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Захиргааны зөвлөл

5.1. Захирлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй захиргааны зөвлөлийг ажиллуулна.

5.2. Захиргааны зөвлөл нь хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбарын эрхлэгч, төвийн дарга, шаардлагатай зарим төслийн удирдагч, санхүүгийн ажилтан зэрэг албан тушаалтнаас бүрдэнэ.

5.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг захирлын тушаалаар батална. Зөвлөлийг хүрээлэнгийн захирал даргалах ба зөвлөл нь хүрээлэнгийн ажлын шуурхай зохион байгуулалт, нэгжийн бүтэц, үйл ажиллагаа, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа, ажиллагсдын нийгмийн баталгааны асуудлыг болон хүрээлэнгийн үйл ажиллагааны дотоод журмуудыг хэлэлцэж батална.

5.4. Хүрээлэнгийн захирал тухайн жилийн батлагдсан төсөв түүний гүйцэтгэл зарцуулалтын талаар захиргааны зөвлөлд мэдээлж байна.

5.5. Захиргааны зөвлөлийн хурлаас хуралдааны тэмдэглэл гаргах ба шаардлагатай үед захирал тэмдэглэлийг үндэслэн тушаал гаргаж болно.

Зургаа. Хүрээлэнгийн захирал

6.1. Хүрээлэнгийн захирал нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, хүний нөөц, захиргаа, санхүү, төсвийн зарцуулалт болон хамт олны өдөр тутмын үйл ажиллагааг

шуурхай удирдлагаар хангаж, хүрээлэнг дотоод, гадаадад төлөөлнө.

6.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааг эрдмийн хамт олон болон ШУА-ийн Ерөнхийлөгчийн өмнө хариуцна.

6.3. Захирлын эзгүй байх хугацаанд албан үүргийг нь хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга орлон гүйцэтгэж болно. Түр орлосон албан тушаалтны шийдвэрийн хариуцлагыг захирал хүлээнэ.

6.4. Захирал нь дор дурьдсан үүрэг хүлээнэ:

а/ Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тушаал, шийдвэр гаргаж, хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

б/ хүрээлэнд мөрдөх журмуудыг боловсруулж батлуулах, мөрдүүлэх;

в/ хүрээлэнгийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлах, мөрдүүлэх, албан хаагчидтай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ, шаардпагатай тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах;

г/ дотоодын шинжлэх ухааны болон бусад байгууллага, их, дээд сургуультай хамтран ажиллахад хүрээлэнг төлөөлж, судалгаа шинжилгээний ажлын үр ашиг, чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг хангаж ажиллах;

д/ ажиллагсдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч, биелэлтийг хангаж ажиллах;

е/ хүрээлэнгийн гадаад харилцааны бодлогыг тодорхойлж гадаад орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

6.5. Захирал нь хүрээлэнг төлөөлж дор дурьдсан эрх эдэлнэ.

а/ дотоодын байгууллага, иргэдтэй харьцаж, эрдэм шинжилгээний ажил, техник, технологи, ажил үйлчилгээний талаар гэрээ хэлцэл байгуулах;

б/ хүрээлэнгийн хөрөнгө, санхүүг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

в/ хүрээлэнгийн салбарын эрхлэгч, төв, нэгжийн дарга, албан тушаалтан, ажиллагсдыг ажилд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах;

г/ гадаад орны эрдэм шинжилгээний байгууллагуудтай ШУА-ийн ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр гэрээ, хэлцэл байгуулах;

д/ хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

6.6. Захирал нь ШУА-ийн ерөнхийлөгчтэй зөвшилцөж хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргыг томилно.

6.7. Захирал нь ШУА-ийн ерөнхийлөгчтэй хамтран ажиллах болон үр дүнгийн гэрээ байгуулж, хүрээлэнгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллана.

6.8. Захирал нь хүрээлэнгийн судалгааны ажлын онцлог, ажиллагсдын тоо, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны цар хэмжээнээс хамааран захиргаа, аж ахуй эрхэлсэн албан тушаалтантай байх асуудлаа ШУА-ийн Ерөнхийлөгчид тавьж шийдвэрлүүлнэ.

Долоо. Эрдэмтэн нарийн бичгийн дарга

7.1. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь төлөвлөгөөт эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гадаад орны болон олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрийн биелэлтийг хангуулах, салбар, нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах, эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн тайлан гаргах ажлыг зохион байгуулж, захирлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөх үүрэгтэй ажиллана.

Найм. Хүрээлэнгийн үндсэн салбарын эрхлэгч, төвийн дарга

8.1. Хүрээлэнгийн үндсэн салбарын эрхлэгч, төвийн дарга нь судалгааны аль нэг төслийг удирдаж болох ба судалгааны төслүүдийг уялдуулан зохицуулах, эрдэм шинжилгээний ажил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа зохион байгуулах үүрэг хүлээнэ.

8.2. Салбар, төвийн бүтцийн нэгжийн жилийн ажлын төлөвлөгөө, тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

Ес. Эрдэм шинжилгээний ажилтан

9.1. Эрдэм шинжилгээний ажилтны сул орон тоонд тухайн үндсэн салбарын эрхлэгч, төв, нэгжийн дарга, хамт олны хурлын саналыг харгалзан сонгон шалгаруулж авна.

9.2. Эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсдын эрх, үүргийг холбогдох хууль, энэхүү дүрэм, дотоод журмаар зохицуулна.

9.3. Эрдэм шинжилгээний ажилтан 65 насанд хүрсэн боловч өөрөө хүсвэл түүний эрүүл мэндийн байдал, ажлын шаардлага, эрдмийн зөвлөлийн саналыг харгалзан гэрээт ажилтнаар ажиллуулж болно.

9.4. Эрдэм шинжилгээний ажилтан нь аттестатчилалд 4 жил тутамд хамрагдсан байна.

Арав. Санхүүжилт

10.1. Хүрээлэн нь улсын төсөв, эрдэм шинжилгээний ажлын суурь санхүүжилт, төсөл хэрэгжүүлэх, гэрээгээр ажиллах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн санхүүгийн бусад эх үүсвэрийг ашиглана.

10.2. Үйл ажиллагааны орлогыг нийгэм, соёл, шагнал урамшил, эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, материал хангамж, аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөх хөрөнгө оруулалтад зохих журмын дагуу хуваарилан зарцуулна.

10.3. Хүрээлэнгийн үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

а/ төсвийн хөрөнгө;

б/ төслийн хөрөнгө;

в/ үйл ажиллагааны орлого;

г/ зөвлөх болон гарааны компаниудын гэрээний орлого;

д/ бусад орлого.

10.4. Төсвийн санхүүжилтийн орлого, зарлагыг Шилэн дансны тухай хуулийн дагуу олон нийтэд тайлагнана.

10.5. Хүрээлэн нь эрдэм шинжилгээ, судалгаа хөгжил, инновацийн үйл ажиллагааг дэмжих, төсвийн бус орлогын эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор эндоумент сан байгуулан ажиллаж болно. Эндоумент сангийн үйл ажиллагааг тусдаа журмаар зохицуулна.

10.6. Хүрээлэнд хэрэгжиж байгаа дотоодын төслийн 10 хүртэл хувь, гадаадын төслийн 20 хүртэл хувийг хүрээлэнгийн шууд бус зардлын санхүүжилт буюу төсвийн бус орлогын эх үүсвэр болгож эндоумент санд хуримтлуулна.

10.7. Хүрээлэнгийн зөвлөх болон гарааны компанийн аж ахуйн үйл ажиллагааг Гарааны компаний хуулийн дагуу хүрээлэнгийн төсвийн болон төсвийн бус орлогын хуримтлал эндоумент сангаас тус тус санхүүжүүлнэ. Сангийн зарцуулалтыг тусдаа журмаар зохицуулна.

10.8. Хүрээлэн нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.

Арван нэг. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Хүрээлэнгийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүрээлэнгийн удирдлага, эрдэм шинжилгээний ажилтнууд гаргах эрхтэй бөгөөд уг саналыг захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, ШУА-ийн Тэргүүлэгчдэд тавьж шийдвэрлүүлнэ.

.... ooOoo